



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/125

Арвайхээр

Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах
тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/267, Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах тухай 2020 оны н/03 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл офицеруудын зайны сургалтыг 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс 7 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй явуулах цэргийн бэлтгэл албаны сургалтыг 6 дугаар сарын 05-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны хооронд, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 5 дугаар сарын 22-ны өдрөөс 6 дугаар сарын 05-ны хооронд тус тус зохион байгуулсугай.

2. Батлан хамгаалах яамны төсвөөс хувиарлагдсан бэлтгэл офицерын тээврийн зардал, нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын зардал болох 14.548.545 (арван дөрвөн сая таван зуун дөчин найман сая таван зуун дөчин тав) төгрөгийг төсвийн дагуу зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл офицер, нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй явуулах сургалтыг заагдсан хугацаанд нь сахилга зохион байгуулалттай явуулж дүнг 2020 оны 07 дугаар сарын 08-ны дотор илтгэхийг Цэргийн штабын дарга (хурандаа М.Дэлгэрсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100267